



ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД

**МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ  
УХААН, СПОРТЫН ЯАМ**

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Бага тойруу 44, Засгийн газрын III байр,  
Утас: 26-22-27, Факс: (976-11) 323589  
E-mail: info@mecss.gov.mn, http://www.mecss.gov.mn

2020. 03. 17 № 2/1479  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Тодруулгын хариу өгөх тухай**

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамнаас 2020 оны 2 дугаар сарын 21-ний өдөр зарласан БСШУСЯ/202002501 дугаартай "Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад гал тогооны тоног төхөөрөмж худалдан авах" тендер шалгаруулалтад оролцохыг сонирхогч этгээдээс тендерийн баримт бичигтэй холбогдуулан ирүүлсэн тодруулгад дараах хариуг хүргүүлж байна.

№	Тодруулга	Тодруулгын хариу
1.	<p>Багц-2: Аяга ариутгагч, хатаагч, Дээжийн хөргөгч, Хөргөгч, Хөлдөөгч"-д шаардсан бараануудад Монгол улсын үндэсний тохирлын гэрчилгээ шаардсан байна. Эдгээр бараанууд нь Монгол улсад үйлдвэрлэгддэггүй учир үндэсний тохирлын гэрчилгээ олгодоггүй.</p> <p>Багц-3: "Цахилгаан махны машин, Бэлтгэлийн ширээ, Шарах шүүгээ, Буузны жигнүүр, Гурил зуурагч, Хоол хийх болон чанах зориулалттай савны цуглуулга, Хоол зөөх зориулалттай сав, Гурван дамжлагат угаалтуур, Ус буцалгагч, 4 давхартай тавиур /сав суулганы/, Данх (5 л)"-д импортын бараа, үндэсний тохирлын гэрчилгээ шаардсан бараанууд холилдож орсон байгааг тодруулж өгнө үү.</p>	<p>Бараа бүтээгдэхүүнүүдийн техникийн тодорхойлолтод дурдсан үндэсний тохирлын гэрчилгээг Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 336 дугаар тогтоол "Дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар стандартын шаардлага хангасан, тохирлын баталгаатай барааны жагсаалт"-ын 14.7-д "Хөргөх, хөлдөөх, хатаах, угаах, ариутгах, савлах, битүүмжлэх, шошголох машин тоног төхөөрөмж, тэдгээрийн сэлбэг эд, анги" гэж заасны дагуу шаардсан болно.</p> <p>Хэрвээ гадаад улсаас импортлон нийлүүлэх тохиолдолд олон улсын стандарт, шаардлагыг хангасан тухай гэрчилгээний хуулбарыг хавсаргаж нотариатаар баталгаажуулан ирүүлнэ. /баталгаат орчуулгын хамт/</p>

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ



Л.ЦЭДЭВСҮРЭН

142091727